



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/91

Цагаан-Уул сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Солонго (Байгаль орчин аялал жуулчлалын яамны ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Батсайхан (Эрдэнэ үйлдвэр Төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилтан)

Я.Хишигдорж (Жолооч)

Нарийн бичгийн дарга: М.Оюунчимэг (Хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн)

2. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний ач холбогдол, үр нөлөөг малчид, иргэдэд сурталчилах, хоршоог хөгжүүлэх, шинээр байгуулах малчдад арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж тайлан мэдээг 14 хоног тутамд дээд шатны байгууллагад хүргэж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Солонго), дэд ажлын хэсгийн ахлагч (У.Аварзэд) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын Газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/